

Маргааны товч:

Хариуцагч татварын улсын байцаагч нараас “Гэгээн хэлхээ” ХХК-ийн албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд татварын хяналт шалгалт хийж 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн №НА-21220000072 дугаар нөхөн ногдуулалтын акт үйлджээ.

Нэхэмжлэгчээс “... Манай компанийн хувьд ашигт малтмалын ямар нэг тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй, зөвхөн дотоодоос худалдаж авсан ашигт малтмалаа экспортод гаргадаг хуулийн этгээд юм. Татварын улсын байцаагч нар нөхөн ногдуулалтын акт гаргах үедээ буюу 2022 онд хяналт шалгалт хийхдээ хүчингүйд тооцогдсон хуулийн заалтыг баримтлан манай компанийг 2019.03.26-ны өдрөөс эхлэн АМНАТ төлөгч болсон гэж үзэн нөхөн ногдуулалт тогтоосон нь хууль бус. Мөн АМНАТ-ийг гэрээний үнээр бус олон улсын зах зээлийн үнийг баримтлан нөхөн ногдуулалтын акт тавьж дааж давшгүй татварын дарамт хүү, торгууль, алданги үүсгэж байгаа нь Татварын ерөнхий хууль, Захиргааны ерөнхий хуульд заасан “шударга байх” зарчмыг зөрчиж байна. Монгол Улсад хайлуур жоншийг хил хүртэл нөхцөлөөр экспортлоход 1 тонн нь ойролцоогоор 90 ам.доллар байдаг бол Засгийн газрын 81 дүгээр тогтоолын дагуу БНХАУ-ын хайлуур жоншны FOB үнэ 1 тонн нь 350 ам.доллар байдаг. Энэ нь экспорт хийж буй хуулийн этгээдүүдийн борлуулалтын орлогыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж, олоогүй орлогод татвар ногдуулж байгаа үйлдэл юм...” гэх зэрэг агуулгаар,

Хариуцагч нар нэхэмжлэлийг эс зөвшөөрч “... Тус компани нь 2019 оны 2,3,4 дүгээр улиралд экспортолсон 3655.19 тонн хайлуур, жоншны хүдэр, баяжмалыг АМНАТ-ийн тайланд дутуу тайлагнасан, мөн 2019 онд 800 тонн, 2020 онд 911.66 тонн, нийт 1711.66 тонн хайлуур жоншны хүдэрт баяжмалыг экспортод гарган борлуулахдаа АМНАТ ногдуулах үнэлгээг зах зээлийн үнээр бус гэрээний үнээр тооцсон нь Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7, 47.1, 47 дугаар зүйлийн 47.1.2, 47.2, 47.2.1, 47.3, 47.3.3-т заасныг тус тус зөрчсөн тул холбогдох хуулийн дагуу нөхөн татвар, торгууль, алданги ногдуулсан нь хууль ёсны тул нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэх агуулгаар тус тус маргажээ.